

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баяндун сумын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2026/015/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Нармандах  
Утас: 7058-4204, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Оюунхэрлэн  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [oyunkherlenb@audit.gov.mn](mailto:oyunkherlenb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
Утас: 7058-4203

2026.03.25 № 416  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.БАТЖАВ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баяндун сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 18.4 сая төгрөгийг дутуу олгосон байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

**Бусад асуудлын хэсэг**

Баяндун сумын 2025 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2025 оны 12 сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 93.3 хувиар "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

2126050229

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ

## Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,157,830.86</b>	<b>1,756,373.4</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	565,342.86	1,118,919.71
3	1.1.3 АВЛАГА	93,800.33	200,516.53
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	498,687.67	436,937.16
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,464,964.55	4,354,192.61
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,464,964.55	4,354,192.61
7	1.2.2.02 Биет хөрөнгө	3,010,323.03	4,041,424.26
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	454,641.52	312,768.35
<b>9</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,622,795.41</b>	<b>6,110,566.01</b>
<b>10</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>128,395.69</b>
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	128,395.69
12	2.1.1.03 Өглөг	-	128,395.69
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,622,795.41	5,982,170.32
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	4,622,795.41	5,982,170.32
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	921,215.02	921,215.02
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	3,259,219.83	4,618,594.74
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	442,360.57	442,360.57
<b>18</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,622,795.41</b>	<b>6,110,566.01</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,226,787.27</b>	<b>4,118,001.95</b>
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,159,789.49	1,804,372.08
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	952,370	1,389,408.39
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	983,138.71	1,424,408.39
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-30,768.71	-35,000
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	74,694.79	148,510.73
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	132,724.71	266,452.97
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	931,585.4	2,313,629.87
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	8,831.8	116,283.67
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,135,412.38	-
<b>11</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,613,745.66</b>	<b>1,964,772.64</b>
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,613,745.66	1,964,772.64
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,523,434.21	1,957,312.64
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	660,581.86	830,449.37
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,825.25	102,844.59
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,437.72	235,739.81
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	61,884.99	54,950.82
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	33,782.07	2,756.95
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	24,632.15	25,012.4
20	1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	12,682.5	11,980
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,318.46	123,282.73
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	464,289.2	570,295.97
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,311.45	7,460
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,613,041.61	2,153,229.31
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	938,542.68	793,854.4
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-938,542.68	-793,854.4
<b>27</b>	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>674,498.93</b>	<b>1,359,374.91</b>

**Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баяндун сумын 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,949,796.48	3,949,796.48
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	- 1,500.00	- 1,500.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,948,296.48	3,948,296.48
4	Тайлант үеийн үр дүн	674,498.93	674,498.93
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,622,795.41	4,622,795.41
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,622,795.41	4,622,795.41
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,622,795.41	4,622,795.41
8	Тайлант үеийн үр дүн	1,359,374.91	1,359,374.91
9	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,982,170.32	5,982,170.32

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,378,106.99</b>	<b>2,808,389.33</b>
<b>2</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,159,789.49</b>	<b>1,804,372.08</b>
3	Орлогын албан татвар	952,370	1,389,408.39
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-30,768.71	-35,000
5	Хөрөнгийн албан татвар	74,694.79	148,510.73
6	Бусад татвар, төлбөр, хураамж	132,724.71	266,452.97
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,869.32	7,453.08
8	Газрын төлбөр	120,594.97	234,743.44
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	7,260.42	24,256.44
<b>10</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>82,905.12</b>	<b>1,004,017.25</b>
11	Нийтлэг татварын бус орлого	74,073.32	169,516.4
12	Тусламжийн орлого	8,831.8	116,283.67
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	718,217.18
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,135,412.38	-
<b>15</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,249,937.21</b>	<b>1,472,669.07</b>
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,249,937.21	1,472,669.07
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,159,625.76	1,465,209.07
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	660,581.86	881,104.08
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,693.25	102,844.59
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	178,624.92	238,304.18
21	Хангамж, бараа материалын зардал	41,993.59	95,160.7
22	Нормативт зардал	1,017.5	-
23	Эд хогшил, урсгал засварын зардал	29,722.05	29,767.75
24	Томилолт, зочны зардал	12,867.5	11,980
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,318.46	16,825.57
26	Бараа үйлчилгээний бусад зардал	134,806.62	89,222.19
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,311.45	7,460
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,128,169.78	1,335,720.26
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	975,859	649,343.91
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	975,859	649,343.91
31	Дотоод эх үүсвэрээр	975,859	649,343.91
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-975,859	-649,343.91
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	132,799.5
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-132,799.5
<b>35</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>152,310.78</b>	<b>553,576.85</b>
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	413,032.08	565,342.86
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	565,342.86	1,118,919.71

**Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баяндун сумын 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,560,951.30	2,139,037.20
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,544,881.80	1,334,979.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,537,121.80	1,327,519.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	923,199.50	829,959.40
210101	Үндсэн цалин	503,673.00	464,080.20
210102	Нэмэгдэл	361,876.70	318,403.90
210104	Урамшуулал	57,649.80	47,475.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	113,887.60	102,788.20
210201	Тэтгэврийн даатгал	77,578.40	69,027.10
210202	Тэтгэмжийн даатгал	9,121.70	9,148.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,459.70	4,246.90
210204	Ажилгүйдлийн даатгал	4,459.70	4,182.20
210205	Эрүүл мэндийн даатгал	18,268.10	16,183.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	254,190.00	235,739.80
210301	Гэрэл, цахилгаан	112,588.90	102,560.20
210302	Түлш, халаалт	134,001.10	127,940.10
210303	Цэвэр, бохир ус	7,600.00	5,239.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,469.10	29,902.30
210401	Бичиг хэрэг	3,925.20	3,036.30
210402	Тээвэр, шатахуун	23,040.00	20,732.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,520.00	2,156.40
210404	Ном, хэвлэл	483.90	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500.00	3,977.60
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	31,592.20	29,767.80
210602	Тавилга	6,568.00	5,475.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400.00	400.00
210604	Урсгал засвар	24,624.20	23,892.20
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	12,960.00	11,980.00
210702	Дотоод албан томилголт	12,960.00	11,980.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,670.00	3,040.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,800.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	760.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	500.00	255.40
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600.00	377.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250.00	88.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,760.00	1,320.00
210807	Газрын төлбөр	1,000.00	999.80
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	158,153.40	84,341.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153,153.40	79,341.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000.00	5,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,760.00	7,460.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,760.00	7,460.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьш илтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,260.00	7,260.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагналыг урамшуулал	500.00	200.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>883,069.50</b>	<b>671,258.70</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	883,069.50	671,258.70
223001	Бусад хөрөнгө	883,069.50	671,258.70
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	133,000.00	132,799.50
230001	Эргэж төлөгдөх зээл	133,000.00	132,799.50
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,560,951.30	2,247,752.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,125,714.80	2,191,765.80
132001	Орон нутгийн төсвөөс	1,389,081.80	1,473,548.60
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	736,633.00	718,217.20
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	414,404.70	47,154.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000.00	47,079.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.00	75.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	408,804.70	-
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	20,831.80	8,831.80
122002	Хандив тусламж /гадаад/	20,831.80	8,831.80
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	303,427.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	412,141.90

**Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баяндун сумын 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>117,321.70</b>	<b>29,140.80</b>
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,321.70	29,140.80
3	122	Тусламжийн орлого	117,321.70	29,140.80
4	1221	Хандив тусламж /дотоод/	117,321.70	29,140.80
5	12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,321.70	29,140.80
6	350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	33,219.70	
7	350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,107.90	29,140.80
8	350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,994.10	
9	II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>117,321.70</b>	<b>29,140.80</b>
10	21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,321.70	29,140.80
11	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,321.70	490.00
12	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	567.00	490.00
13	210104	Урамшуулал	567.00	490.00
14	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	56.40
15	210201	Тэтгэврийн даатгал	-	41.60
16	210202	Тэтгэмжийн даатгал	-	4.90
17	210205	Эрүүл мэндийн даатгал	-	9.80
18	2104	Хангамж, бараа материалын зардал	-	11,228.30
19	210401	Бичиг хэрэг	-	881.00
20	210402	Тээвэр, шатахуун	6,920.90	4,264.80
21	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	120.00
22	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	711.50	5,962.50
23	2107	Томилолт, зочны зардал	2,140.00	-
24	210702	Дотоод албан томилолт	2,140.00	-
25	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,947.70	10,600.00
26	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,947.70	10,600.00
27	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,034.60	6,766.10
28	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,034.60	6,766.10
29	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,000.00	-
30	21320	Бусад урсгал шилжүүлэг	40,000.00	-
31	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,000.00	-

**Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар 1 зөвлөмж өгсөн.

Нийт хамрах хүрээний байгууллагуудаас илрүүлсэн санхүүгийн тайлангийн аудитын 48.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 12.5 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

**3.1 Зөвлөмж**

**Илрүүлэлт:** Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системд тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн акт зэргийг мэдээлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.5-д "тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системд тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн актыг байршуулж байх.

**Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баяндун сумын 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн акт зэргийг мэдээлээгүй.	1	-					1	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>

/сая төгрөгөөр/

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			